

АЖЛЫН ДААЛГАВАР

БАГЦ-1: “УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА”

2024 оны 08 дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Ажлын зорилго: Монгол улс дахь улс төрийн хүрээ буюу «дээд (өндөр)» түвшний авлигын шинж чанар, цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөл, хор уршгийг тодорхойлж, цаашид анхаарах чиглэлийг тодруулахад оршино.

Хугацаа: Хуанлийн 80 өдөр

Эхлэх хугацаа: 2024 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Дуусах хугацаа: 2024 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Байршил: Авлигатай тэмцэх газар

Үндэслэл	Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь хэсэгт авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байдаг.
Өмнө нь хийгдсэн судалгаа	“Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г 2008 оноос хойш жил тутам зохион байгуулж ирсэн. Улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийг 2017 он хүртэл нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 оноос эхлэн хоёр хүрээг тусад нь авч үзэж, “Улс төрийн хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа” болон “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа” гэж зохион байгуулсан.
Ажлын хамрах хүрээ	Нийтийн алба, шүүх, хууль сахиулах салбар, хэвлэл мэдээллийн салбар, бодлогын болон олон нийтийн санаа бодлын судлаач, бизнесийн салбар, олон улсын байгууллага, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагыг төлөөлөх ердийн мэргэжилтний түвшнээс илүү хэмжээний ойлголт, мэдлэг, туршлагатай 65 шинжээч. /Экспертэд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна./
Цар хүрээ	“Улс төрийн хүрээ” гэж Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан удирдах албан тушаал хашиж буй этгээд албан тушаалын эрх мэдэл, нэр нөлөөгөө албаны болон хувийн зорилгоор хэрэгжүүлж, ашиглаж байгаатай холбоотой нийгмийн харилцааг авч үзнэ.
Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	Ерөнхий шаардлага: <ul style="list-style-type: none">• Судалгаа, шинжилгээний ажил 3-аас доошгүй жил эрхэлсэн, ажлын дадлага, туршлагатай, ажлын даалгаврыг бүрэн гүйцэтгэх хангалттай мэдлэг, ур чадвартай, социологич, эрх зүйч, судлаач бүхий төрийн болон төрийн бус байгууллага, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байх;• Өмнө нь ижил төстэй чиглэлээр судалгаа хийж байсныг давуу тал гэж үзнэ. Бусад шаардлага:

	<ul style="list-style-type: none"> • Судлаачдын бүрэлдэхүүн 5-аас доошгүй байх; • Судалгаа шинжилгээний программ SPSS, Excel дээр өгөгдөл боловсруулах ахисан түвшний мэдлэгтэй байх; • Дүн шинжилгээ хийх-тоон ба чанарын судалгаа хийх; • Харьцуулсан судалгаа хийх; • Дата-анализ хийх;
Тайлангийн хуваарь	<ul style="list-style-type: none"> • Гэрээ байгуулж ажил эхэлснээс хойш хуанлийн 7 хоног тутамд ажлын явц, үр дүнг тайлагнаж байна. • Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны холбогдох ажилтнуудтай нягт хамтран ажиллах бөгөөд үйл ажиллагаагаа тус албаны даргад тайлагнаж ажиллана.
Тайланд тавигдах шаардлага	<p>Захиалагчаас баталсан судалгааны асуулга, аргачлалын дагуу шинжээчдээс авсан судалгаанд үндэслэн боловсруулсан тайлан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Судалгааны зорилго, зорилтод нийцсэн байх • Захиалагчаас баталсан аргачлал, асуумжийн дагуу хийж гүйцэтгэсэн байх
Хүлээгдэж буй үр дүн, бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> • Ажлын даалгаврын дагуу боловсруулсан тоон болон чанарын судалгааны тайлан, судалгааны аргачлал, аргазүйг боловсронгуй болгохтой холбоотой санал. • Судалгааны тайлан нь Монгол хэл дээр бичигдсэн байна. • Судалгааны ажил /тайлан, санал зөвлөмж/-ын хэлбэржүүлэлт /формат/ нь төрийн албан хэрэг хөтлөлтийн журам, судалгааны ажилд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн, хэл зүйн болон утга найруулгын алдаагүй байна.
Санал ирүүлэх	<p>Дээрх шаардлагыг хангасан этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт/албан бичгээр; • Хуулийн этгээдийн товч бичмэл танилцуулга; • Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; • Ажлын даалгавар гүйцэтгэх бүрэлдэхүүний танилцуулга, ажлын туршлага; • Судалгааны ажил гүйцэтгэж ирсэн дадлага, туршлагыг нотлох баримт;

Сонирхсон этгээд мэдүүлгээ дор дурдсан хаягаар **2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 15:00 цагаас өмнө** битүүмжлэн ирүүлнэ үү.

Хаяг:

**Монгол Улс, Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний алба
5 дугаар хороолол, Сөүлийн гудамж 41
Улаанбаатар хот 14250**

Холбоо барих утас: 70112565

----oOo----

АЖЛЫН ДААЛГАВАР

БАГЦ-2: “ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА”

2024 оны 08 дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Ажлын зорилго: Монгол улс дахь хууль хяналтын байгууллагын хүрээ буюу «дээд (өндөр)» түвшний авлигын шинж чанар, цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөл, хор уршгийг тодорхойлж, цаашид анхаарах чиглэлийг тодруулахад оршино.

Хугацаа: Ажлын 60 өдөр

Эхлэх хугацаа: 2024 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Дуусах хугацаа: 2024 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Байршил: Авлигатай тэмцэх газар

Үндэслэл	Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь хэсэгт авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байдаг.
Өмнө нь хийгдсэн судалгаа	“Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г 2008 оноос хойш жил тутам зохион байгуулж ирсэн. Улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигын талаарх төсөөллийг 2017 он хүртэл нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 оноос эхлэн хоёр хүрээг тусад нь авч үзэж, “Улс төрийн хүрээнд авлигын талаарх төсөөллийн судалгаа” болон “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигын талаарх төсөөллийн судалгаа” гэж зохион байгуулсан.
Ажлын хамрах хүрээ	Нийтийн алба, шүүх, хууль сахиулах салбар, хэвлэл мэдээллийн салбар, бодлогын болон олон нийтийн санаа бодлын судлаач, бизнесийн салбар, олон улсын байгууллага, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагыг төлөөлөх ердийн мэргэжилтний түвшнээс илүү хэмжээний ойлголт, мэдлэг, туршлагатай 65 шинжээч. /Экспертэд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна./
Цар хүрээ	“Хууль хяналтын байгууллагын хүрээ” гэж хууль сахиулах чиг үүрэг гүйцэтгэж буй шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ, авлигатай тэмцэх, тагнуул, хил хамгаалах, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг авч үзнэ.
Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	Ерөнхий шаардлага: <ul style="list-style-type: none">• Судалгаа, шинжилгээний ажил 3-аас доошгүй жил эрхэлсэн, ажлын дадлага, туршлагатай, ажлын даалгаврыг бүрэн гүйцэтгэх хангалттай мэдлэг, ур чадвартай, социологич, эрх зүйч, судлаач бүхий төрийн болон төрийн бус байгууллага, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байх;• Өмнө нь ижил төстэй чиглэлээр судалгаа хийж байсныг давуу тал гэж үзнэ.

	<p>Бусад шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Судлаачдын бүрэлдэхүүн 5-аас доошгүй байх; • Судалгаа шинжилгээний программ SPSS, Excel дээр өгөгдөл боловсруулах ахисан түвшний мэдлэгтэй байх; • Дүн шинжилгээ хийх-тоон ба чанарын судалгаа хийх; • Харьцуулсан судалгаа хийх; • Дата-анализ хийх;
Тайлангийн хуваарь	<ul style="list-style-type: none"> • Гэрээ байгуулж ажил эхэлснээс хойш хуанлийн 7 хоног тутамд ажлын явц, үр дүнг тайлагнаж байна. • Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны холбогдох ажилтнуудтай нягт хамтран ажиллах бөгөөд үйл ажиллагаагаа тус албаны даргад тайлагнаж ажиллана.
Тайланд тавигдах шаардлага	<p>Захиалагчаас баталсан судалгааны асуулга, аргачлалын дагуу шинжээчдээс авсан судалгаанд үндэслэн боловсруулсан тайлан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Судалгааны зорилго, зорилтод нийцсэн байх • Захиалагчаас баталсан аргачлал, асуумжийн дагуу хийж гүйцэтгэсэн байх
Хүлээгдэж буй үр дүн, бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> • Ажлын даалгаврын дагуу боловсруулсан тоон болон чанарын судалгааны тайлан, судалгааны аргачлал, аргазүйг боловсронгуй болгохтой холбоотой санал. • Судалгааны тайлан нь Монгол хэл дээр бичигдсэн байна. • Судалгааны ажил /тайлан, санал зөвлөмж/-ын хэлбэржүүлэлт /формат/ нь төрийн албан хэрэг хөтлөлтийн журам, судалгааны ажилд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн, хэл зүйн болон утга найруулгын алдаагүй байна.
Мэдүүлэг ирүүлэх	<p>Дээрх шаардлагыг хангасан этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт/албан бичгээр; • Хуулийн этгээдийн товч бичмэл танилцуулга; • Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; • Ажлын даалгавар гүйцэтгэх бүрэлдэхүүний танилцуулга, ажлын туршлага; • Судалгааны ажил гүйцэтгэж ирсэн дадлага, туршлагыг нотлох баримт;

Сонирхсон этгээд мэдүүлгээ дор дурдсан хаягаар **2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 15:00 цагаас өмнө** битүүмжлэн ирүүлнэ үү.

Хаяг:

**Монгол Улс, Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний алба
5 дугаар хороолол, Сөүлийн гудамж 41
Улаанбаатар хот 14250**

Холбоо барих утас: 70112565

----oOo----